

**“ТӨРИЙН ОРОН СУУЦНЫ КОРПОРАЦИ” ТӨХХК-ИЙН
2023 ОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШИН,
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛ**

2024.01.10

“Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК нь хүлээгдэж буй гүйцэтгэлээр хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрийн бүтээн байгуулалтын үр дүнд бий болсон бүтээгдэхүүн үйлчилгээний борлуулалт, түрээсийн үйл ажиллагаанаас нийт 13.8 тэрбум төгрөгийн орлого олж, 18.9 тэрбум төгрөгийн зардал гарган 6.7 тэрбум төгрөгийн алдагдал хүлээсэн. 2023 оны үйл ажиллагааны зардал 2.96 тэрбум төгрөг төлөвлөснөөс нийт 2.97 тэрбум төгрөгийг зарцуулж ажилласан.

2023 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр нийт авлага 109.4 тэрбум, нийт өглөг 266.6 тэрбум төгрөг байгаагаас 243.0 тэрбум төгрөгийн богино хугацаат өглөг, 23.5 тэрбум төгрөгийн урт хугацаат өглөг байна. Энэ нь “Дамжуулан зээлдүүлэх гэрээ”-ээр төсөвт эргэн төлөгдөх нөхцөлтэй авсан урт хугацаат өр төлбөр юм.

№	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	х.нэгж	2022 оны гүйцэтгэл	2023 оны	
				Төлөвлөгөө	Хүлээгдэж буй гүйцэтгэл
1	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт				
	а/ Гол нэр төрлөөр	Биет	627	274	240
	б/ Үнийн дүнгээр	мян.төг	2,259,238.4	1,446,569.6	959,376.5
2	Нийт орлого	мян.төг	8,958,577.3	22,176,346.8	13,853,729.4
3	Нийт зардал	мян.төг	9,798,589.6	22,169,869.9	18,919,534.7
	а/ Ерөнхий ба удирдлагын зардал	мян.төг	1,035,307.3	2,967,835.6	2,979,224.8
4	Татварын өмнөх ашиг	мян.төг	(840,012.3)	6,476.9	(6,758,824.4)
5	Цэвэр ашиг /алдагдал/	мян.төг	(840,012.3)	5,829.2	(6,758,824.4)
6	Төсвийн төлбөрт нийт дүн	мян.төг	544,423.2	548,273.2	2,374,897.6
7	Төрийн өмчийн ногдол ашиг	мян.төг	-	-	-
8	Нийт ажиллагсадын тоо	хүн	54	50	50
9	Нийт цалингийн сан	мян.төг	1,171,357.0	1,578,220.4	1,160,739.8
10	Нэг ажилтны дундаж цалин	мян.төг	1,807.6	2,630.4	2,173.4
11	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	төг	1.100	1.000	1.401
12	Хөрөнгө оруулалт	мян.төг	274,583.6	985,100.0	24,384.0
	а/ Үндсэн хөрөнгө худалдан авалтын зардал	мян.төг	25,284.9	166,100.0	24,384.0
	б/ Солонго 1.2 төслийн үндсэн хөрөнгө худалдан авалт	мян.төг		819,000.0	-
13	Нийт авлага	мян.төг	125,837,586.4	70,767,943.0	109,486,625.9
	Үүнээс: Найдваргүй авлага	мян.төг	-	-	-
14	Нийт өглөг	мян.төг	262,273,320.7	223,968,546.1	266,617,173.5
	а/ Богино хугацаат өр төлбөр үүнээс:	мян.төг	63,573,320.7	201,029,241.9	243,057,722.2
	б/ Урт хугацаат өр төлбөр үүнээс:	мян.төг	198,700,000.0	22,939,304.2	23,559,451.3

ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ОРОН СУУЦНЫ ТӨСЛҮҮДИЙН ЯВЦЫН ТАЛААР

"Солонго 1, 2" орон сууцны төсөл

2023 онд төслийн бэлтгэл ажлын зардалд нийт 1.69 тэрбум төгрөгийн санхүүжилт хийхээр төлөвлөсөн ба гүйцэтгэлээр нийт 121.3 сая төгрөгийн санхүүжилт хийгдээд байна. Энэхүү хөрөнгө оруулалтын зардлууд нь эх үүсвэртэй уялдан санхүүждэг.

Төслийн зорилго: Бага, дунд орлоготой иргэдийн орлогод нийцсэн орон сууцаар хангах; Улаанбаатар хотын агаар, хөрсний бохирдлыг бууруулахад хувь нэмэр оруулах.

Хэрэгжих хугацаа: 2021 – 2027 он

Байршил: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 21 дүгээр хороо

Хүчин чадал: 5,002 айлын орон сууц болон 1,280 хүүхдийн 1 сургууль, 280 хүүхдийн 2 цэцэрлэг, ахмад залуучуудын хөгжлийн төв, сэргээн засах төв, хорооны барилга, цэцэрлэгт хүрээлэн.

Санхүүжилт: БНСУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээл (орон сууцны барилга), Монгол улсын төсвийн хөрөнгө (нийгмийн дэд бүтцийн барилга байгууламж, гадна инженерийн 1 дүгээр хэлхээний шугам сүлжээ)

Зээлийн мэдээлэл: 266.8 сая ам. доллар, жилийн хүү – 0.15%, хугацаа – 40 жил.

Төслийн хэрэгжилтийн явц: 2023 оны 12 сарын байдлаар-15%

2019 он	Төслийн ТЗЗҮ-г боловсруулсан.
2020 он	Тусгайлан зээлийн хэлэлцээрийг байгуулсан.
2021 он	Төслийн хүрээнд зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээг БХБЯ БНСУ-ын "SAMOO" JV түншлэлтэй байгуулсан.
	1,280 хүүхдийн 1 сургууль, 280 хүүхдийн 1 цэцэрлэгийн барилга угсралтын ажил эхэлсэн.
	Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний загвар зураг төслийг боловсруулж, батлуулсан.
2022-2023 он	Төслийн гадна инженерийн 1-р хэлхээний шугам сүлжээний зураг төсөл, төсөв боловсруулах ажил эхлэсэн.
	Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний загвар зураг төсөлд өөрчлөлт оруулж, батлуулсан.
	Барилгын ажлын зураг төсөл, төсвийг боловсруулж, батлуулсан.
	Төслийн орон сууцны барилга угсралтын ерөнхий гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж, гүйцэтгэгчээр БНСУ-ын "Колон Глобал" корпораци шалгарч, БХБЯ-тай 2023 оны 8 дугаар сард гэрээ байгуулсан бөгөөд урьдчилгаа 30% санхүүжилтаас 10% санхүүжилтийг шийдвэрлэсэн.
	Гүйцэтгэгч компанийн зүгээс "Солонго-1, 2" төслийн талбайн бэлтгэл ажлыг 2023 оны 9 дүгээр сараас эхлүүлж хамгаалалтын түр хашаа барих, түр цахилгаан хангамж татах ажлыг хийж гүйцэтгэсэн.
	Төслийн гадна инженерийн 1 дүгээр хэлхээний шугам сүлжээний зардал болох 24.5 тэрбум төгрөгөөс 2024 оны Улсын төсөвт 13,5 тэрбум төгрөг суугдсан.



"Эко Яармаг-1" гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төсөл

2023 онд төслийн бэлтгэл ажлын зардалд нийт 815.4 сая төгрөг, үүнээс 480.0 сая төгрөгийг иргэдэд түр суурьшуулах зардалд олгохоор төлөвлөсөн ба гүйцэтгэлээр нийт 456.1 сая төгрөгийн санхүүжилт хийгдээд байна. Энэхүү хөрөнгө оруулалтын зардлууд нь эх үүсвэртэй уялдан санхүүждэг.

Зорилго: Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төсөл

Хэрэгжих хугацаа: 2021-2027


Байршил: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 4-р хороо, нийт 146 нэгж талбар

Хүчин чадал: 16 давхар, 14 блок, 1,800 айлын орон сууц

Санхүүжилт: Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлбэрээр хэрэгжүүлж байна.

Төслийн хэрэгжилтийн явц: 2023 оны 12 сарын байдлаар-20%

2014 он	Төсөл хэрэгжүүлэх батламж, захирамж авсан.
2014-2015 он	82 нэгж талбарын газрыг "Буянт Ухаа 1" болон "Буянт Ухаа 2" хорооллын орон сууцаар сольсон.
2015-2018 он	Байрзүйн зураг, Инженер-геологийн суурь судалгаа, ТЗЗҮ, Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ, Хэсэгчилсэн Ерөнхий төлөвлөгөөний загвар зургийг боловсруулсан.
2019-2020 онд	Төслийн 1-р ээлжийн барилгажих талбайг чөлөөлөх ажил эхэлж, хамрагдсан иргэдийг түр суурьшуулах ажил хийгдсэн.
	Төслийн 1-р ээлжийн барилгажих талбайн хог хаягдал цэвэрлэх, хөрсний ариутгал хийх ажлууд хийдэг, барилгын түр хашааг барьж байгуулсан.
2021 он	Төслийн 1-р ээлжийн талбайн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний эх загвар зургийг шинэчлэн боловсруулж, батлуулсан.
2022-2023 он	Төслийн 1-р ээлжийн орон сууцны барилга угсралтын бэлтгэл ажлыг эхлүүлж, түр цахилгаан хангамж татах, инженер техникийн ажилчдын түр байр байршуулах, эхний ээлжийн 4 блок барилгын суурийн газар шорооны ажлыг 2023 оны 5-7 дугаар сард гүйцэтгэж, нийт 108 мянган м3 шороог зайлуулсан.



"Залуус-1" орон сууцны төсөл

2023 онд төслийн бэлтгэл ажлын зардалд нийт 1.1 тэрбум төгрөгийн санхүүжилт хийхээр төлөвлөсөн ба гүйцэтгэлээр нийт 0.3 сая төгрөгийн санхүүжилт хийгдээд байна. Энэхүү хөрөнгө оруулалтын зардлууд нь эх үүсвэртэй уялдан санхүүждэг.

Төслийн зорилго: Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулж төвлөрлийг сааруулах замаар шинэ суурьшлын бүсийг хөгжүүлэх хүрээнд ажлын байртай уялдсан иргэдийн орлогод нийцсэн орон сууцаар хангах.

Төслийн хүрээнд мэдээлэл технологийн салбарыг кластераар хөгжүүлэх, гарааны бизнесийг дэмжих, дээд сургууль, зарим төрийн байгууллагыг шилжүүлэн суурилуулах замаар эдийн засгийн өсөлт, төвлөрлийг сааруулах, агаарын бохирдлыг бууруулах, залуучуудад зориулсан ажлын байр бүхий орлогод нийцсэн орон сууцны цогцолбор хороолол баригдаж ашиглалтад орно.

Хэрэгжих хугацаа: 2021 – 2028 он

Байршил: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 21 дүгээр хороо

Хүчин чадал: 5,616 айлын орон сууц болон ниймийн дэд бүтцийн 8 төрлийн барилга, байгууламж, олон нийтийн хэрэглээний 13 төрлийн барилга, байгууламж.

Санхүүжилт: Монгол улсын төсвийн хөрөнгө (нийгмийн дэд бүтцийн барилга байгууламж, гадна инженерийн 1 дүгээр хэлхээний шугам сүлжээ), Төр, хувийн хэвшлийн түншлэл (орон сууцны барилга, олон нийтийн барилга байгууламж)

Төслийн хэрэгжилтийн явц: 2023 оны 12 сарын байдлаар-15%

2021 он	ТЭЗҮ, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний загвар зургийг боловсруулж, батлуулсан.
2022 он	Орон сууц, нийгмийн дэд бүтцийн барилга байгууламжийн зураг төсөл, төсөв 2022 оны 2 дугаар улиралд батлагдсан. Төслийн хүрээнд шинээр баригдах дулааны станцын ТЭЗҮ 2022 оны 2 дугаар улиралд батлагдсан. Гадна инженерийн шугам сүлжээний зураг төсөл, төсөв 2022 оны 2 дугаар улиралд хэсэгчлэн батлагдаж, төслийн эхний ээлжийн барилгын талбайн дэд бүтцийн шугам сүлжээний угсралтын ажил 2022 оны 5 дугаар сард эхлэсэн. Төслийн хүрээнд шинээр баригдах хонгилын системийн угсралтын ажил 2022 оны 3 дугаар улиралд эхлэсэн.
2023 он	Төслийн эхний ээлжийн барилгын талбайн инженерийн дэд бүтцийн угсралтын ажил 2023 оны 4 дүгээр сараас үргэлжилэн явагдсан. Төслийн эхний ээлжийн инженерийн дэд бүтцийн ажлын зардал болох 29,9 тэрбум төгрөгөөс 2024 оны Улсын төсөвт 11,8 тэрбум төгрөг суугдсан.



Орон нутагт хэрэгжүүлэх төслүүд

Хөвсгөл аймаг дахь “Зүүн мөрөн” 480 айлын орон сууц, Ховд аймаг дахь 120 айлын орон сууц, Хэнтий аймаг дахь 120 айлын орон сууц барих төслүүдийг тус тус хэрэгжүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.



ТӨРИЙН ТҮРЭЭСИЙН ОРОН СУУЦНЫ САН

“Засгийн газрын 2016 оны 38 болон 169 дүгээр тогтоол, 2016 оны 298 дугаар тогтоолуудын хүрээнд нийт 1,512 айлын 96.3 тэрбум төгрөгийн үнэ бүхий орон сууцыг Түрээсийн орон сууцны санд шилжүүлсэн. Түрээсийн орон сууц хөтөлбөрийн хүрээнд Засгийн газрын 2019 оны 138 дугаар тогтоолоор “Түрээсийн орон сууцыг өмчлүүлэх журам”-ыг баталж 2023 оны байдлаар нийт түрээсийн орон сууцнаас 880 айлын орон сууцыг түрээслээд өмчлөх гэрээ байгуулан 5 жилийн хугацаанд орон сууцны үнийн 30 хувийг хуваан төвлөрүүлэн ажиллаж байгаа бөгөөд одоогийн байдлаар түрээслээд өмчлөх гэрээнээс нийт 12.36 тэрбум төгрөг, энгийн түрээсийн гэрээнээс 24.5 тэрбум төгрөг, нийт 36.9 тэрбум төгрөгийг Түрээсийн орон сууцны сангаас төвлөрүүлээд байна. Мөн “Түрээсийн орон сууц” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах хүрээнд “ТОСК-ОСЗС” программыг нэвтрүүлснээр нээлттэй, ил тод, шуурхай ажиллах боломж бүрдсэн.

ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛ

1. “Буянт-Ухаа-1, 2” төсөл, “Аймаг бүрт 1000 айлын орон сууц” төсөл, “40,000 айлын орон сууц” хөтөлбөрүүдийн хүрээнд баригдсан орон сууц, гарааш, зоорийн давхрын үлдэгдлийг 2020-2023 онд бүрэн барагдуулах: Уг төлөвлөгөөний хүрээнд 2023 онд 1.44 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 1.13 тэрбум төгрөгийн борлуулалтын орлогыг 240 иргэнээс төвлөрүүлээд байна.
2. “ТОСК” ТӨХХК нь 2011-2015 онд орон сууцны барилга болон гадна инженерийн шугам, сүлжээ, цэвэрлэх байгууламжийн бүтээн байгуулалтад зориулж хувийн хэвшлүүдтэй “Хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааны гэрээ” байгуулж барилгын санхүүжилтийг хийсэн. Гэрээний дагуу санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын эргэн төлөлт хугацаандаа хийгдээгүйгээс үүссэн авлагын үлдэгдэл 18.1 тэрбум төгрөгт хүрээд байгаа бөгөөд эдгээр авлагуудаас 2023 онд ХОХАГ-тэй хууль, хяналтын байгууллагаар шийдвэрлэгдэж байгаа 3 байгууллагаас 4.7 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 31.1 сая төгрөгийн авлага төлөгдсөн нь “Бэрэн констракшн” ХХК, “Могоул скай” ХХК-ийн шүүх, шүүхийн шийдвэрийн асуудал шийдвэрлэгдээгүйтэй холбоотой.
3. Төрийн түрээсийн орон сууцны санд шилжүүлсэн орон сууцнаас 5.5 тэрбум төгрөгийн түрээсийн орлогыг төвлөрүүлнэ: 2023 онд 621 иргэний 1.8 тэрбум төгрөгийн энгийн түрээс, 880 иргэний 4.0 тэрбум төгрөгийн түрээслээд өмчлөх гэрээний эргэн төлөлт, нийт 5.8 тэрбум төгрөгийн түрээсийн орлого төвлөрүүлсэн. /25 хувийн шимтгэл суутгасан орлого/
4. Түрээслээд өмчлөх үйл ажиллагааны орлогыг 2023 онд 745.8 сая төгрөгөөр төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 1.19 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлсэн. Учир нь 2024 онд нэмж 106 иргэнтэй гэрээ байгуулсанаар түрээслээд өмчлөх гэрээний орлого нэмэгдэж, уг орлогоос суутган авдаг 25 хувийн шимтгэлийн орлого нэмэгдсэн.
5. Төрийн түрээсийн орон сууцны санд шилжүүлсэн 1289 айлын орон сууцны төлбөр 82.3 тэрбум төгрөгөөс 2019 оноос улсын төсөвт суулгах замаар 5.0 тэрбум төгрөгийг авч Хөгжлийн банкнаас авсан зээлийн төлбөрийг төлсөн ба 2020-2023 онд шат дараатай улсын төсөвт суулгах замаар “Түрээсийн орон сууцны сан”-д шилжүүлсэн 1,289 айлын орон сууцны 82.3 тэрбум төгрөгийг төвлөрүүлнэ: 2023 оны улсын төсөвт 5.0 тэрбум төгрөг суусан ба Дамжуулан зээлдүүлэх 2023 оны гэрээний дагуу 5.0 тэрбум төгрөгийг төсвөөс авч Хөгжлийн банканд үнэт цаасны хүүгийн төлбөрт шилжүүлсэн.
6. “Солонго 1, 2” төсөл хэрэгжиж, барилга угсралтын ажил эхэлж байгаатай холбоотойгоор төслийн 2023 онд хийгдэх ажлын техник хяналтын орлого болох 4.46 тэрбум төгрөгийг улсын

төсөвт тусган авахаар төлөвлөсөн боловч хэрэгжээгүй. Энэ нь төслийн барилга угсралтын ажлын гэрээ 2023 оны 9 дүгээр сард байгуулагдсан ба дээрх төлөвлөсөн орлого 2024 онд шилжин хойшилсон.

ЗАРДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛ

1. Үйл ажиллагааны зардал: 2023 онд 2.96 тэрбум төгрөгийн зардал төлөвлөснөөс 2.97 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй ажилласан.
2. Санхүүгийн зардал: 2023 онд Хөгжлийн банканд үнэт цаасны төлбөрт 5.0 тэрбум, хүүгийн төлбөрт 14.6 тэрбум төгрөгийг төлөхөөр төлөвлөсөн боловч санхүүгийн нөхцөл байдлаас шалтгаалан үндсэн төлбөрөөс төлөлт хийгдээгүй, хүүнд 15.2 тэрбум төгрөгийг хугацаанд нь төлсөн.
3. Борлуулсан бүтээгдэхүүний өртөг: 2023 онд 1.15 тэрбум төгрөгийн зардал төлөвлөсөн боловч 636.2 сая төгрөгийн зардал гараад байна. Энэ нь 2023 онд борлуулалтад хүлээн зөвшөөрч бүртгэсэн борлуулсан бүтээгдэхүүн төлөвлөсөн хэмжээнд хүрээгүйтэй холбоотой.
4. Үйл ажиллагааны бус зардал: 2023 онд 21.5 сая төгрөг төлөвлөснөөс 19.2 сая төгрөгийн зардал гараад байна.

АВЛАГА

1. Түрээсийн орон сууцны авлагын үлдэгдэл: Засгийн газрын 2016 оны 38, 169 дүгээр тогтоолоор “Түрээсийн орон сууцны сан”-д шилжсэн 1,512 орон сууцны үнэ 62.3 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байгаагаас 2023 оны төсөвт 5.0 тэрбум төгрөгийг суулган авч үлдэгдэл авлага 57.3 тэрбум төгрөг болж буурахаар төлөвлөсөн ба гүйцэтгэлээр биелсэн.
2. Хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааны гэрээтэй байгууллагаас авах авлагын үлдэгдэл дүн: 2023 онд 3 байгууллагын 4.4 тэрбум төгрөгийг төлүүлж, үлдэгдэл авлагыг бууруулж 13.4 тэрбум төгрөгт хүргэхээр төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр нийт 31.0 сая төгрөг төлөгдөж энэхүү төлөвлөгөө биелэгдээгүй. /тайлбар нь дээрх орлого дээр/
3. Хөдөлгөөнт тоног төхөөрөмж авлага: Засгийн газрын 2022 оны 220 дугаар тогтоолоор Хөдөлгөөнт тоног төхөөрөмжийн авлагыг Батлан хамгаалахын яаманд шилжүүлэхээр байгаа бөгөөд уг тогтоолын хүрээнд Хөгжлийн банк, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны хамтарсан ажлын хэсэг ажилласан боловч 2023 онд үр дүнд хүрээгүй тул уг авлагын төлөвлөгөө биелээгүй. 2024 онд ажлын хэсгийг шинэчлэн байгуулж тоног төхөөрөмжийн өр төлбөрийг балансаас балансад шилжүүлэх ажил хийгдсэнээр энэхүү тоног төхөөрөмжийг худалдан авахтай холбоотой гарсан авлага буурах боломжтой. Тоног төхөөрөмжийн гаалийн төлбөрт 1.6 тэрбум төгрөгийг 2023 оны 10 дугаар сард Гаалийн ерөнхий газар компанийн данснаас суутган аваад байна.

ЗЭЭЛ, ӨР ТӨЛБӨР

1. “Түрээсийн орон сууцны сан”-д шилжүүлсэн орон сууцны төлбөр 82.3 тэрбум төгрөгийг үе шаттайгаар улсын төсөвт суулгах замаар барагдуулахаар төлөвлөсөн ажлын хүрээнд Улсын төсвөөс авсан хүүгүй эх үүсвэрийг Дамжуулан зээлдүүлэх гэрээний хуваарийн дагуу эргэн төлөлт хийнэ. Дамжуулан зээлдүүлэх гэрээний дагуу 2019-2023 онд 25.0 тэрбум төгрөгийг төсвөөс авч, 2023 онд гэрээний хуваарийн дагуу 1.200.0 сая төгрөгийг төлсөн. Үлдэгдэл дүн: 22.0 тэрбум төгрөг.
2. Засгийн газрын 2022 оны 220 дугаар тогтоолын хүрээнд гаргасан “ТОСК бонд”-ын төлбөрт 2023 онд төсвөөс авах 5.0 тэрбум төгрөгийн төлбөрийг шилжүүлэн төлөхөөр төлөвлөсөн боловч компанийн санхүүгийн нөхцөл байдлаас шалтгаалан хүүгийн төлбөрт шилжүүлсэн.
3. Сангийн яаманд төлөх ОССК-иас ТОСК-д шилжсэн 14.6 тэрбум төгрөгийн зээл, хүүгийн төлбөрийн гэрээний хугацааг сунгуулах, хүүг зогсоох талаар Сангийн яамтай уулзалт зохион байгуулж, ажиллахаар төлөвлөж байна. 2023 онд өр төлбөрөөс төлөгдөөгүй.

4. Барилгын гүйцэтгэлийн санхүүжилтийн үлдэгдэл, Чанарын баталгааны өглөгийн үлдэгдэл төлбөрийг барагдуулах: 2023 онд 500.0 сая төгрөгийг төлөхөөр төлөвлөсөн боловч санхүүгийн нөхцөл байдлаас шалтгаалан 50.0 сая төгрөг төлсөн. Өглөгийн үлдэгдэл 1.5 тэрбум төгрөг.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛ

2023 онд Монгол Улсын Засгийн газраас “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг баримтлан ажилласан ба нийт 166.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалт төлөвлөснөөс 24.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг худалдан авсан. 2023 онд төлөвлөгдсөн 128.4 сая төгрөгийн компьютер, техник хэрэгсэл худалдан авахаар сонгон шалгаруулалт зарласан боловч шаардлагад нийцэх компани орж ирээгүй, дахин сонгон шалгаруулалт зарласан тул 2023 онд багтаж худалдан авалт хийгээгүй.

-----oOo-----